

“МОНОС ХҮНС” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Огноо: 2024-04-20

Хурал хийсэн газар: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20-р хороо, Сонсголонгийн гудамж, Монос хүнс ХК-ийн Эрүүл мэндийн хүнсний үйлдвэрийн 3 давхарт байрлах хурлын танхимд хуралдав.

Эхэлсэн цаг: 11:00

Дууссан цаг: 13:30

Хурлыг зарласан: Монос Хүнс ХК

Хурлын зохион байгуулагч бүрэлдэхүүн:

Хурлын дарга: ТУЗ-ийн дарга Х.Ананд

Хурал зохион байгуулах комиссын дарга: Үйл ажиллагаа хариуцсан захирал П.Тодрол

Тооллогын комиссын дарга: Санхүүгийн менежер Э.Амарболд

Тоологын комиссын гишүүд: Санхүүгийн шинжээч П.Энхбаяр

Бүтээгдэхүүний менежер Ц.Дөлгөөнмайдар

Тэмдэглэл хөтлөсөн: ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Н.Цагаанхүү

Хэлэлцэх асуудал:

1. Компанийн 2023 оны санхүүгийн тайланд аудит хийсэн хөндлөнгийн компанийн аудитын дүгнэлтийг танилцуулах,
2. Компанийн 2023 оны үйл ажиллагаа, санхүүгийн тайланд өгсөн ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцүүлэх,
3. ТУЗ-ийн 2024 оны төсвийг хэлэлцүүлэх,
4. Ногдол ашиг хуваарилахгүй тухай ТУЗ-ийн хурлаас гарсан тогтоолыг танилцуулах,
5. Компанийн дүрмийн нэмэлт өөрчлөлтийг хэлэлцүүлэх,

Монос Хүнс ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дарга Х.Ананд хурлыг нээж, дэгийг танилцуулан, 2024 оны 02 дугаар сарын 19-ны өдрийн 31/02 дугаартай “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай” тогтоолыг уншиж хурал хуралдах өдөр, цаг байршил, хурлын зарыг түгээсэн сувгуудыг мэдээлж, тооллогын комиссын бүрэлдэхүүнийг уншиж танилцуулаад Тооллогын комиссын дарга Э.Амарболдыг индэрт урив.

Тооллогын комиссын дарга Э.Амарболд: Хувьцаа эзэмшигчиддээ энэ өдрийн мэнд хүргэе. Хувьцаа эзэмшигчдийн бүртгэл үргэлжилсээр байна, 11:00 цагийн байдлаар бүртгэгдсэн хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг тасалбар болгоод ирцийн тогтоолоо танилцуулья.

Тооллогын комиссын тогтоол №01 уншиж танилцуулав. Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3.1, 67.3.2, 67.3.8, 68.4 дахь хэсгийг тус тус үндэслэн Компанийн саналын эрх бүхий энгийн нийт 408,850,428 ширхэг хувьцаанаас саналын эрхтэй 305,935,435 ширхэг хувьцаа буюу 74.84%-ийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хуралд бүртгүүлж, зайнаас холбогдсон буюу танхимд оорийн биеэр хүрэлцэн ирж оролцож байгаа тул хурлыг хүчин төгөлдөрт тооцож хурлын үйл ажиллагааг эхлүүлэв.

Хурлын дэгийн дагуу ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал А.Отгондарь “Монос Хүнс” ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулав. Тайланг тэмдэглэлд хавсаргав.

Танилцуулах асуудал 1: Хурлын дэгийн дагуу БДО аудит ХХК-ийн төлөөлөн Л.Баярцогзол “Монос Хүнс” ХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн хөндлөнгийн аудитын компани БДО аудит ХХК-аас гаргасан дүгнэлтийг танилцуулав. Дүгнэлтийг тэмдэглэлд хавсаргав.

Танилцуулгад: БДО аудит ХХК-ийн болон Монос хүнс ХК-ийн санхүүгийн тайланд хяналт хийсэн гэрээт ажлын баг бүрэлдэхүүний товч мэдээлэл, санхүү тайлангийн аудитын зорилго, НББ-ийн бодлогын сонголт, тооцоолол, аудитын дүгнэлтийн товч агуулга, аудитын гол асуудлууд, зөвлөмж хүргүүлсэн илрүүлэлтийн талаар мэдээлж танилцуулав.

Хэлэлцэх асуудал 1: Хурлын дэгийн дагуу хурлын дарга Х.Ананд ТУЗ-ийн 2023 онд хийсэн хурлын мэдээлэл, ТУЗ-аас гаргасан дагаж мөрдөж байгаа эрх зүйн баримт бичгийн талаар мэдээлж,

“Монос Хүнс” ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлантай танилцаад ТУЗ-өөс өгсөн дүгнэлтийг танилцуулав. Дүгнэлтийг тэмдэглэлд хавсаргав.

Танилцуулгад: 2023 онд ТУЗ ээлжит хурал 4, ээлжит бус хурал 8, тогтоол 32, ТУЗ дэргэдэх АХ 9, НДЦУХ 3, СБХХ 2 удаа хуралдсан. ТУЗ хараат бус гишүүн солигдсон, ТУЗХ-аас 5 журам батлан мөрдөж байгаа, компанийн засаглалын кодексын үнэлгээг 2 удаа хийж зохицуулагч байгуулагаар хянан баталгаажуулсан талаар тайлагнав.

Хэлэлцэх асуудал 2: Хурлын дэгийн дагуу ТУЗ-ийн гишүүн, Аудитын хорооны дарга О.Лхагвасүрэн 2023 оны ТУЗ-ийн төсвийн зарцуулалт болон 2024 оны ТУЗ-ийн төсвийн төслийг танилцуулав. Төсвийн саналыг тэмдэглэлд хавсаргав.

Танилцуулгад: 2023 оны ТУЗ-ийн төсвийн гүйцэтгэл 73% буюу 109.2 сая төгрөг төсөвлөснөөс 79.8 сая төгрөгийг зарцуулсан, 2024 оны төсөвт ээлжит хурлын төсвийг нэмэгдүүлж 12 сая, хувьцаа эзэмшигчдийн хурлын зардал 40 сая, гишүүд цалин 71.3 сая, сургалтын зардалд 2 сая нийт 132.5 сая төгрөгийн төсвийг батлуулахаар санал оруулсан.

Хэлэлцэх асуудал 3: Хурлын дэгийн дагуу Гүйцэтгэх захирал А.Отгондарь “Монос хүнс” ХК-ийн дүрмийн нэмэлт өөрчлөлтийг танилцуулав. Дүрэмд оруулж байгаа нэмэлт өөрчлөлтийг тэмдэглэлд хавсаргав.

Танилцуулгад: Дүрмийн 1.4 хаягийн өөрчлөлт, 7.2 ТУЗ гишүүний тоо 11, хараат бус гишүүний тоо 5, 7.15. ТУЗ дэргэдэх хороод: 1. Аудит эрсдэлийн хороо, 2. Нэр дэвшүүлэх хороо, 3. Цалин урамшууллын хороо, 4. Стратеги бизнес хөгжлийн хороо, 7.16 Аудит эрсдэлийн хорооны чиг үүрэг, 7.17. Нэр дэвшүүлэх хорооны чиг үүрэг, 7.18. Цалин урамшууллын хорооны чиг үүрэг, 8.11.9 Гүйцэтгэх захирлын хүлээх үүрэг, 9.1. Эрх бүхий албан тушаалтны заалт, 10 дугаар бүлэг болон 12 дугаар бүлгийг нэгтгэсэн, дугаарлалтууд засагдсан зэргийг дэлгэрэнгүй заалт бүрээр танилцуулав.

Танилцуулах асуудал 2: Хурлын дэгийн дагуу хурлын болон ТУЗ-ийн дарга Х.Ананд 2024 оны 02 сарын 19 өдрийн 30/02 тоот тогтоолоор батлагдсан “Ногдол ашиг хуваариалхгүй тухай” тогтоолыг танилцуулж, тараахгүй байгаа шалтгаан нөхцлийг танилцуулав.

Тооллогын комиссын дарга Э.Амарболд цахимаар санал хураах зааврыг дэлгэц дээр танилцуулав.

Хурлын дарга Х.Ананд: Санал хураалтыг эхлүүлсэн байна. Санал хураалт өгч байх хугацаанд хурлын дэгийн дагуу асуулт хариултын цаг эхлэж байна. Хуралд оролцож байгаа та бүхэн заалнаас мөн цахимаар асуултаа чөлөөтэй асууж болно.

Асуулт-Хувьцаа эзэмшигч 1: 2024 оны борлуулалтын төлөвлөгөө хэд байгаа бэ?

Хариулт: ТУЗ-ийн дарга Х.Ананд: 40 орчим тэрбум буюу одоогийнхоос 10 тэрбумаар өсгөж байгаа.

Асуулт -Хувьцаа эзэмшигч 2: 2023 оны санхүү тайлангаас харахад урт хугацаат өр төлбөр нэмэгдсэн, урт хугацаат өр төлбөрийг эздийн өмчтэй харьцуулахад 2,5 байгаа нь хөрөнгө оруулагчдад тийм таатай үзүүлэлт биш байна. Урт хугацаат өр төлбөрийг хэрхэн үр ашигтай зарцуулах төлөвлөгөө гарсан уу? Дундын хугацаанд хүүгийн дарамт хир үүсэх бэ? Хэдэн хувийн хөнгөлөлттэй зээл авсан бэ? Эргэлтийн хөрөнгийн буцалтгүй тусламж гэж ойлголоо, энэ талаар хариулт өгнө үү?

Хариулт: ТУЗ гишүүн, гүйцэтгэх захирал А.Отгондарь: МFC төсөл нь 24 тэрбумын хөрөнгө оруулалттай, хөрөнгө оруулалтаа 4.5 жилд цэвэр ашгаасаа нөхнө гэсэн тооцоололтой, хөнгөлөлттэй зээлийн тухайд хүнсний салбарын монголын томоохон компаниуд зээлийн түвшин өндөр болсон энэ үед таатай нөхцлөөр олгогдож байгаа зээл гэж бүгд авахыг хүсэж хандсан. 6% хүүтэй, авсан байгаа. Одоо бол зээлийн дундаж хүү ямар байгааг та бүхэн мэдэж байгаа, компани байгаль орчин засаглалын нөхцлийг хангаад ногоон зээл хүсэхэд дотоодын арилжааны банкууд 15% хүүтэй зээл олгож байгаа энэ үед хямд эх үүсвэртэй зээл юм. Хөрөнгө оруулалтын өгөөжийг нөхнө, удахгүй шинэ бүтээгдэхүүнүүд гарна. Экос ус анх гарснаасаа хойш манай компанийн борлуулалтын орлогын ихэнх хувийг эзлэж байгаа бүтээгдэхүүний 1 болсон. 2023 оны бүтээгдэхүүний тасалдлын 3 тэрбум төгрөгийн тасалдлыг Экос усны тасалдлаас үүссэн. Тиймээс бид тасалдалгүй ажилласан бол цэвэр ашгийн нөхцөл өөр байх байлаа, иймээс бид үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлээд байна. Тиймээс бид өрийн дарамтанд орох нөхцөл байхгүй байна.

Асуулт-Хувьцаа эзэмшигч 3: Сайн байцгаана уу? МFC төслийн хөрөнгө оруулалт хаанаас санхүүжилтээ авсан бэ?

Хариулт: ТУЗ гишүүн, гүйцэтгэх захирал А.Отгондарь: МФС төслийн хөрөнгө оруулалт 24 тэрбум, төсөл бүрэн хаагдаагүй байна. Гүйцэтгэлийн явцад барилгын материалын хомсдолоос үнэ нэмэгдсэн зүйл байгаа, гүйцэтгэлээ явцад ТУЗХ-даа тайлагнаад хяналттай явж байна. Эх үүсвэр нь ХХАА-ы хөнгөлөттэй зээл, ногоон зээл, үндсэн үйл ажиллагаа гэсэн эх үүсвэрээс бүрдэж байгаа.

Асуулт-Хувьцаа эзэмшигч 4 /цахимаар санал ирүүлсэн/: Хог хаягдлыг ангилан хаях талд зөвхөн Экос усны савыг ангилан хаях талаар дурдаж ярилаа. Бусад бүтээгдэхүүний талд ямар бодлого барьж байна бэ? Жишээлбэл “Витос” брэндийн шилийг дахин ашиглах талд компани ямар бодлоготой ажиллах бэ?

Хариулт: Гүйцэтгэх захирал А.Отгондарь: Компани ISO 14001 менежментийн тогтолцоо хэрэгжүүлж байгаа, үүний хүрээнд 5 аудитор ирж ажиллахдаа хог хаягдлын менежментийг шалгасан. Үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүнээс гарч байгаа хог хаягдлыг зохистой хаях менежментийг бид хэрэгжүүлж байна. Үйлдвэрлэлийн явцтай танилцах үед та бүхэнд мэдээлэл өгөх болно. Хуванцарын хаягдлыг шийдэх талд бид ажиллаж байна. Витос шотын шилийг дахин ашиглах талд одоогоор шийдэлгүй байна, жижиг шилийг угааж ариутгаж ашиглах нь хүнсний аюулгүй байдал талд эрсдэлтэй байдаг. Бид хог хаягдлыг ангилан зөв хаях талд хэрэглэгчидтэйгээ хамтран маркетинг хийж ажиллана.

Асуулт-Хувьцаа эзэмшигч 5: Сайн байцгаана уу? Компани эрэлтээ хангаж дийлэхгүй байна гэж танилцуулсан. Шинээр барьсан үйлдвэр монголын зах зээлийн хэдэн хувийг хангах бэ? Экспорт хийхэд үйлдвэрлэлийн хүчин чадлын хэдэн хувийг зарцуулах бэ?

Хариулт: Хурлын дарга Х.Ананд: Үйлдвэр хуурай, шингэн гээд 2 үйлдвэрээс бүрдэж байгаа. Экос ус 3 нэр төрөл гаргана, монголын зах зээлийг бүрэн хангахыг зорьж байгаа. Шингэн хүнсний үйлдвэрт витос, цэнэг, шот гээд бүтээгдэхүүнүүдийг бас байгаа. Хуурай хүнсний үйлдвэр монголын зах зээл төдийгүй гадаадын зах зээлийг хангах болно. Шингэн хүнсний хувьд Экос усыг гадаадад гаргах боломжгүй, тухайн улсдаа салбараа байгуулахгүй л бол усыг гадагшаа гаргах боломжгүй юм. Одоо суурилуулсан тоног төхөөрөмж нь зөвхөн монгол улсын зах зээлийг хангах юм.

Гүйцэтгэх захирал А.Отгондарь: Савласан цэвэр ус нь стратегийн хүнст ордог экспортын зөвшөөрөлгүй бүтээгдэхүүн юм.

Асуулт-Хувьцаа эзэмшигч 6 /Энхрийлэнгийн аав Жавхлан/: Жил бүр ирж хуралдаа оролцож байна. Улам сайжирсан байна, өнгөрсөн жилийн хурлын үеэр ярьж байсан барилгаа бариад хурлаа хийж байгаа нь гайхамшигтай байна. Хурлын презентаци таалагдсан, одоо үед шаардлагатай мэдээллийг агуулсан байна. Бид хөрөнгийн зах зээлд хөрөнгөө босгоод үргэлжлүүлээд явж байгаа, цаашид бид хөгжүүлэх ёстой. Компани нэмэлт хувьцаа гаргах нь ойлгомжтой. Хөрөнгийн зах зээлд хүмүүсийг хувьцаа авахуулахын тулд дансны үнэ буюу нийт хөрөнгөөс өр төлбөрийг хасаад гаргадаг. Тайланд сая 22 тэрбум гэж гарснаас дансны үнийг гаргахад нэг ширхэг хувьцааны үнэ 53 төгрөг гэсэн ханш гарч байна. Өчигдрийн хаалтын ханш 92 төгрөг байсан тэгэхээр зах зээлийн үнээсээ 1 дахин доогуур байна. БДО аудит хараат бусаар сайн ажилласан байна. Үнэлгээний компани үнэлгээгээ бага гаргасан байна, татвар бага төлөх гээд үнэлгээгээ бага гаргасан байж болно. Ирээдүйд хөрөнгө оруулалтыг татахын тулд үнэлгээг өндөр гаргах хэрэгтэй, ингэснээр дансны үнэ ханшаас өндөр байх ёстой. Ингэснээр гадаадын хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулалт хийнэ. Энэ талд ямар бодлого баримталж байгаа бэ? Дараа жил энэ барилгаа өндөр үнээр үнэлээд нэмэгдүүлэх хэрэгтэй.

Хариулт: ТУЗ-ийн гишүүн Ц.Цэцэгбадам: Стандартын дагуу дахин үнэлгээ хийлгээд бүртгүүлсэн. Шинэ үйлдвэр үнэлгээ хийж бүртгээгүй байгаа. Үнэлгээгээ хийлгээд бүртгэх үед зах зээлийн үнээр өндөр болно. Барилга комисс ажиллаад гэрчилгээ гарахаар бүртгэнэ, тоног төхөөрөмж ажиллаад эхлэхээр бүртгэнэ. Тэр үед хөрөнгийн үнэлгээ нэмэгдэнэ.

Асуулт-Хувьцаа эзэмшигч 7 /Г.Шинэбаяр цахимаар санал ирүүлсэн/: Цаашид ямар томоохон төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа бэ?

Хариулт: Хурлын дарга Х.Ананд: 2024, 2025 оны гол зорилго нь энэ үйлдвэрээ бүрэн ашиглалтанд оруулж, бүтээгдэхүүний тасалдалгүй ажиллана. Мөн экспортын хувьд Киргизстан улсын 7 сая иргэнд зориулж 200 салбартай газраар бүтээгдэхүүнээ худалдаалахаар байршуулсан. Сая Киргизстан улсын Лекарь компани манай албан ёсны төлөөлөгчөөр ажиллаж байгаа, 9 сар гэхэд бүх супермаркетуудтай гэрээ хийж байршуулахаар ажиллаж байна. Цаашид 19 сая хүн амтай Казакстан улсыг зорьж байгаа.

Дотооддоо ресторан зэрэг хорека сувгуудаар байршуулахын тулд шилэн савалгааг судалж байна. Энэ нь тусдаа шугамтай үйлдвэр байх учир судалгааны ажлуудыг эхлүүлсэн байгаа.

Хариулт-Гүйцэтгэх захирал А.Отгондарь: Хамгийн ойрын хугацаанд хэрэгжүүлэх төсөл бол агуулахын төсөл байгаа. Шингэн хүнсний үйлдвэр бүтээгдэхүүний тэлэлт хийгээд байхаар энэ бүтээгдэхүүн нь овор хэмжээ ихтэй байдаг тул агуулахын хүчин чадал дутагдаад эхэлсэн байгаа. Бид үйлдвэрлэсэн бүтээгдэхүүндээ стандартын шаардлага тавиад тэрийг хадгалах хураах газар нь стандартыг хангахгүй байх байдал үүсдэг учир стандартын шаардлага хангасан агуулахтай болохоор зорьж байна.

Хариулт: Хурлын дарга Х.Ананд: Бид агуулах түрээслэх үү, барьж байгуулах уу гэдгийг судлаж ТУЗ-ийн хурал, түүний дэргэдэх хороодоор хэлэлцүүлэн шийдвэрлэх болно.

Асуулт-Хувьцаа эзэмшигч 8 /цахимаар Алтанцогт/: Экос усны хуванцар савыг нимгэн болгох тал дээр хийсэн ажил байгаа юу? Бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн албаны талаар мэдээлэл өгнө үү?

Хариулт-Гүйцэтгэх захирал А.Отгондарь: Төслийг судлахдаа хуванцарыг 60%-аар бууруулах үйлдвэрлэлийг бид оруулж байгаа, МУ-ын хувьд энэ шинэ стандарт юм. Удахгүй нимгэн бөглөөтэй шинэ ус гарна. Энэ нь бага хуванцартай болно. Та бүхэн үйлдвэрээр аялахдаа одоогийн усны сав, бөглөөг харьцуулаад харж болно.

Бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн алба 3 брэндийн 27 бүтээгдэхүүнийг гаргахаар төлөвлөн ажиллаж байна. Цэнэг брэнд дээр уушги цэвэрлэх цэнэгийн шот гарахаар хөгжүүлэлт хийгдээд сав баглаа боодлыг захиалаад байна. Ингээд нэр төрөл нь 7 болно. Манай чухал албаны нэг юм.

Хурлын дарга Х.Ананд: Хуванцарыг багасгаснаар манайд 2 эерэг нөлөө үзүүлж байна. Эхнийх нь хуванцарыг багасгаснаар байгалийн хог хаягдлыг багасгаж байна. 2 дахь нь зардлыг багасгаж байна. Ингэснээр ашиг өснө.

Асуулт-Хувьцаа эзэмшигч 9 /чатаар/: Үйлдвэртэй танилцаж болох уу ?

Хариулт-Гүйцэтгэх захирал А.Отгондарь: Бид үйлдвэрийн нээлтийг удахгүй хийнэ, энэ жил хэдэн удаа үйлдвэртэй танилцах тур хийнэ.

Асуулт- Хувьцаа эзэмшигч 10: ТУЗ төсөв дээр нэмэгдсэн 2 төсвийн талаар тайлбар өгнө үү? Ээлжит хурлын зардал болон ээлжит бус хурлын цалин нэмэгдсэн байна.

Хурлын дарга Х.Ананд: ТУЗ-ийн хурлын үеэр танхим түрээс болон бусад зардал гардаг мон гишүүдийн оролцооны цалинг нэмсэн, ингэснээр сайн гишүүнийг ажиллуулах боломжтой.

Хурлын дарга Х.Ананд: За асуулт хариултын цаг дууссан байна. Санал хураалтын дүнг танилцуулна уу гээд тооллогын комиссын дарга Э.Амарболдыг урья.

Тооллогын комиссын дарга Э.Амарболд: Саналаа идэвхтэй өгсөн хувьцаа эзэмшигчдэдээ баярлалаа. Тооллогын комиссын зүгээс санал хураалтын дүнг танилцуулья.

Батлах асуудал 1: “Монос Хүнс” ХК-ийн 2023 оны үйл ажиллагаа, санхүүгийн тайланд өгсөн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах тухай” санал хураалтын дүн:

1. Зөвшөөрсөн – 305,210,765 ширхэг буюу 99.88% ;
2. Татгалзсан – 346,659 ширхэг буюу 0.11% ;
3. Түдгэлзсэн – 9,156 ширхэг буюу 0.003% ;
4. Санал өгөөгүй/хүчингүй- байхгүй тул Компанийн тухай хуулийн 63.5 дахь хэсэгт зааснаар шийдвэр хүчинтэй.

Батлах асуудал 2: “Монос хүнс ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны төсвийг батлах” санал хураалтын дүн:

1. Зөвшөөрсөн – 305,561,032 ширхэг буюу 99.998% ;
2. Татгалзсан – 5,548 ширхэг буюу 0,002 % ;
3. Түдгэлзсэн – 0 ширхэг буюу 0% ;
4. Санал өгөөгүй/хүчингүй хуудас байхгүй тул Компанийн тухай хуулийн 63.5 дахь хэсэгт зааснаар шийдвэр хүчинтэй.

Батлах асуудал 3: “Монос хүнс ХК-ийн дүрмийн нэмэлт өөрчлөлтийг батлах” санал хураалтын дүн:

1. Зөвшөөрсөн – 305,084,250 ширхэг буюу 99,84% ;

2. Татгалзсан – 479,968 ширхэг буюу 0.16% ;
3. Түдгэлзсэн – 2362 ширхэг буюу 0,004% ;
4. Санал өгөөгүй/хүчингүй хуудас байхгүй тул Компанийн тухай хуулийн 63.5 дахь хэсэгт зааснаар шийдвэр хүчинтэй.

Хурлын дарга Х.Ананд: Санал хураалтын дүнд үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарах 01, 02, 03 дугаарт тогтоолыг уншиж танилцуулав. 2012 онд Монос хүнс ХК-ийг байгуулж байсан тэр үед 2 тэрбумын борлуулалтын орлоготой, ашиггүй ажиллаж байсан. Өнөөдөр 12 жилийн дараа бид үүнийг 12 дахин өсгөсөн байна. 2019 онд анх IPO гаргаж хөрөнгө оруулалт татан дэргэдэх ШХҮ-ийг босгож байсан. Одоо бид энэ үйлдвэрээ бүрэн ашиглалтанд оруулснаар ирэх 3-5 жилд борлуулалтаа 2-3 дахин өсгөх боломжтой үүд хаалга нээгдэж байна. Манай бүтээгдэхүүн зах зээл дэх бүтээгдэхүүнээс ялгаатай онцлог байдаг. Удахгүй Вита-500 гэсэн бүтээгдэхүүнээ гаргаж үүгээрээ хүн амын одор тутмын витамин С-ийн хэрэглээг хангах юм. Экспортоор Киргизстан улсын 200 эмийн санд бүтээгдэхүүнээ байршуулан үйл ажиллагаагаа эхэлсэн байгаа. Энэ нь дараа дараагийн удаад улам өргөжин тэлсээр ирэх 5 жилд Төв Азид бүтээгдэхүүнээ гаргах боломжтой юм. Бид дахин шилэн савалгаатай бүтээгдэхүүн гаргах зэргээр судалгаа хийж бизнес хөгжлөө улам тэлсээр байх болно. Хувьцаа эзэмшигч та бүхэнтэйгээ бид хамтдаа байж, ирэх жил бидэнд том тэлэлт, том хүлээн авалтыг төлөвлөж байна, ингээд хувьцаа эзэмшигчид та бүрхэнтэйгээ хамтдаа тэлье гэж уриалан хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын үйл ажиллагаа 13 цаг 30 минутанд дуусав.

Хурлын дараа үйлдвэртэй танилцах учир хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл энхийн ажилтан зааварчилгаа өгөв.

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА *Н.Цагаанхүү* Н.ЦАГААНХҮҮ

ТЭМДЭГЛЭЛ ХЯНАСАН:

ХУРЛЫН ДАРГА *Х.Ананд* Х.АНАНД

